

**НАГ, Х№-1, Д-1, ХН-112, НУ-1**

### **ДАВС ХУЖРААС ГААЛЬ ХУРААХ ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ:** Тус аймгийн нутгийн доторх улсын сангийн эрхлэн ашигладаг баялгийн зүйлүүдээс дотоодын гааль хурааваас зохино.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ:** Тус аймгийн доторх Холбуулч, Борын овоо, Гурван тэшиг, Баацагааны зэрэг газрын давс Дөргөн нуур, Өнгө нуурын цайдам хоёр газрын хужирыг нь цөм цэцэрлэг мандлын аймгийн хөрөнгө болгосугай.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ:** Аливаа энгийн хүмүүс малтан авч хэрэглэх буюу худалдаалах давс хужар зэргэд цөм дотоодын гааль хурааваас зохино. Үүнд тайлбарлах нь: Аливаа хүний зөвхөн хувьд хэрэглэх ганц уналгаар малтан авагчдаас гаалийг хэтрүүлнэ.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ:** Аливаа хүн гааль хураалгаваас зохих эл зүйлийг бүрнээ гааль хураах албаны газарт мэдүүлэн хүрэхээр одож байцаан үзүүлж гаалийг хураалгаваас зохино.

**ТАВДУГААР ЗҮЙЛ:** Эл зүйлийн гаалийн хэргийг харьяат аймгийн яамнаа захируулан гаалийг сангийн хэлтсээс эрхлэн гүйцэтгэн шийтгүүлнэ.

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ:** Давс, хужрын үнийг аймгийн яамнаас тохиолдсон цагийн үнийг баримтлан тогтоож зарлан тушааж журамлан шийтгүүлнэ.

**ДОЛООДУГААР ЗҮЙЛ:** Эл зүйлийн үнээс гаалийн дүрмийг дагаж зуун хувиас зургаан хувийн гааль хураана. Үүнд тайлбарлах нь: Эл орлогыг аймгийн захиргааны дүрмийн ёсоор гурван хувийн хоёр хувийг харьяат олон хошуудад хуваан олгоно.

**НАЙМДУГААР ЗҮЙЛ:** Гааль хураахад олгуулах үлдээхэд бүх хуудсыг аймгийн яамнаас тусгайгаар шилүүлж мөнхүү хуудсанд яамны тэмдгийг дарж хэрэглүүлэхэд бэлтгэнэ.

**ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ:** Аливаа хүн юм зүйлээс гааль хураалгахад гаалийн мөнгийг эрх биш бэлхнээ тушаалгахаас гадна хураалгаж гүйцмэгц тэмдэгт хуудсыг шийтгэн гаргаж зохих хүнд үнэмлэх тэмдэг болгомуй.

**АРАВДУГААР ЗҮЙЛ:** Эл нэр бүхий газруудад гааль хэргийг эрхлүүлэх бичээч хавсаргасан түшмэл нэг, үзэгч хавсаргасан гааль нэг, зурлага хавсаргасан цагдаа нэг, эдгээр хүмүүсийг үргэлж суулгана.

**АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ:** Энэхүү гаалийн салбарын газар хэрэглэх гэр хэрэглэл зэрэг зүйлийг аймгийн яам ба нутгийн харьяат газраас гаргуулан үнэ хөлсийг аймгаас тавин олгуулваас зохино.

**АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ:** Эл албан хаагчдын цалин хэрэглээг аймгийн яамнаас жич тогтоон олгуулваас зохино.

**АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ:** Аливаа хүмүүс гааль хураалгавас зохих юмыг сэмхэнээр хулгуун авах тоог дарагдуулах, жич элдэв аргаар нууж далдлах зэргийн явдал хэрэв буй ахул байцаан гаргасан хойно дарагдуулсан зүйлээс гаалийн дүрмийн ёсоор хурааваас зохих гаалийн дээр арван хувь нэмэгдүүлэн торгоно. Үүнд тайлбарлах нь: Дарагдуулсан нуусан зүйл хэрэв нэгэнт гааль хураалгасны хойно илэрвээс тухайн эрхэлсэн хүмүүсийг сайтар нягтлан байцааж гэм учрыг тодорхойлон уг ашигласан зүйлийг зохигчдоос хөөн

гаргуулж шийтгээд биеийг уг албанаас шууд хөөн зайлуулж уг зүйлийг тусгай орлого болгон албанаа хураана.

**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ:** Гаалийн хэрэгт оролдсон түшмэл албаны хүнээр өөр өөрийн эрхлэн шийтгэх сахих хэрэгт осолд олтгойдох буюу түргэлэн шийтгэхгүй нуурчлах, дарлах, удагдуулах хүлээгдүүлэх шамшигдуулах зэргийн зүйлгүйгээр явбаас шууд аймгийн яамнаа мэдүүлэн ирүүлж чангалан байцаалж хууль ёсоор цээрлүүлэн шийтгэнэ.

**АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ:** Арван гуравдугаар зүйлд дурдсан хэргийг энгийн хүн мэдүүлж гэрчлэн харж мэдүүлэхгүй нам хуйвалдан дарагдуулваас дарагдуулсан этгээдийг нэгэн адил цээрлүүлэн шийтгүүлнэ.

**АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ:** Арван гуравдугаар, тавдугаар зүйлүүдэд дурдсан хэргийг гэрчлэн харах ба байцаан баригчдад уул торгуулийн мөнгөний зуун хувийн таван хувийг шагнан олгоно.

**АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ:** Эл гааль хураах газруудаас хураасан гаалийн мөнгийг цаг цагийн эцэст хураангуйлан цэс үйлдэж үлдсэн тэмдэгт хуудасны хамтаар ..... аймгийн улаа сумаар мэдүүлэн хүргүүлж байваас зохино.

**АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ:** Энэхүү дүрмийг харьяат аймгийн их хуралд оруулан батлан тогтоолгож дагаж шийтгүүлнэ.

**АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ:** Үүнээс дээш тогтоосон дүрмийн дотор хаяа учир гүйцэлдээгүй зүйл харах ахул цагийг дагаж залруулан засах зэргээр гүйцэтгэн шийдүүлмүй.

**Арван тавдугаар он арван сарын есөн**